

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл ба арга зүй

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмжөөр хангахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
3. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт;
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт;
5. Хэрэглэгчийн үнэлгээ.

3.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

“2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г 8 зорилтын хүрээнд 49 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгаснаас 57% нь тогтмол хийгддэг ажил, 12.2% нь өмнөх жилийн, үлдсэн 30.8% нь шинэ үйл ажиллагаанууд тус тус байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 91.8%.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн гол арга хэмжээнүүдээс дурдвал: ЭМЯ-ны чиглэлийн дагуу орон нутаг, анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын сувилагч, бага эмч нарын гадаад сургалт болон “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан, эрүүл мэндийн үндэсний тооцоог 2016-2022 оноор хийж дуусгасан, эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн дашбоардуудыг хийх ажлыг эхлүүлж, донорын бүртгэлийг цахимжуулах, дуудлагын үйлчилгээний санаачлагатай ажилласан, дуудлага зохицуулах үйлчилгээг сайжруулах (зөвлөгөө мэдээлэл өгөх, цаг цуцлах)-д анхаарсан байна.

Гэвч төлөвлөсөн үйл ажиллагааны талаас илүү хувь нь (57%) тогтмол хийгддэг ажлууд, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг үр дүнд чиглүүлж тодорхойлоогүй зэрэг дутагдлууд байна.

Хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээ:

- ӨОУ-ын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- Эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийн төслийг шинэчлэн боловсруулах.

3.2 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

2024 оны үнэлгээ дунджаар 90.0%-тай байна. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн гүйцэтгэл хангалттай хэрэгжсэн гэж үзсэн.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг үнэлдэг 12 шалгуур үзүүлэлтээс 6 шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг журмаар тогтоосон ба бусад 6 шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг байгууллага оны эхэнд тоон болон чанарын үзүүлэлтээр төлөвлөөгүйгээс зорилтот түвшингүй тайлагнасан. Тайлан бичилт оновчгүй байна.

3.3 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ

2024 жилийн эцсийн байдлаар 70.7 хувь буюу “Хэрэгжих шатанд” байна.

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 77.8 хувь. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг ил тод байршуулаагүй;

- Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 71.7 хувь. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ зэрэг 2 мэдээллийг ил тод байршуулаагүй;

- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 82.3 хувь; Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн зэрэг 2 мэдээллийг ил тод байршуулаагүй.

- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 100.0 хувь;

- Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал - 21.7 хувь. Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл (авлигын эсрэг, хүний эрх, жендэр болон бусад) зэрэг 5 мэдээллийг ил тод байршуулаагүй;

Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, мэдээллийг үнэн зөв, бүрэн,

иргэнд ойлгомжтой байхаар байршуулж, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгахад анхаарах

3.4 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үнэлгээний дүн **50.0** хувь бөгөөд өмнөх оны түвшнээс сайжраагүй, дунджаас муу дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:

1. Телемедицин ашиглаж авсан оношилгоо, эмчилгээний зөвлөгөөний хувь
2. Эрүүл мэндийн ажилтны мэдээний нэгдсэн сангийн баяжилт, тогтвортой үйл ажиллагаа
3. Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагсдын тоо /тайлагнаагүй/
4. Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо /тайлагнаагүй/
5. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь /тайлагнаагүй/

3.5 Хэрэглэгчийн үнэлгээ

2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ дунджаар 90 хувь буюу 4.5 оноо байна.

Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ 2024 онд үйлчлүүлсэн 85 хэрэглэгчийн үнэлгээг түүвэрлэж гаргасан.

ЭМХТ-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олоход хүндрэлтэй байдаг гэж 30.6%, ажилтан алба хаагчид үйлчлүүлэгчийн холбогдсон асуудлын хүрээнд 29.4% нь бүрэн мэдээллээр хангаагүй, хэрэглэгчийн гаргасан өргөдөл, гомдлыг ажилтан шуурхай шийдвэрлэсэн эсэхэд 24.7% нь шийдвэрлээгүй гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.

Дөрөв. Цаашид анхаарах асуудал, зөвлөмж

4.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын урт, дунд, богино хугацааны бодлогод нийцүүлэх, хууль тогтоомжоор өгсөн үүрэг даалгаврыг тусгах, шинэлэг арга хэмжээг илүү тусгах, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үр дүнд чиглүүлж тодорхойлоход анхаарах;

4.2 Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 2.2, 2.3, 2.4 дэх хэсгийн дагуу төлөвлөгөөг боловсруулах, тус журмын 4.8 дахь хэсгийг баримтлан төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилтын хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын үзүүлэлтээр оны эхэнд төлөвлөж, түүний дагуу тайлагнах.

4.3 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах;

4.4 Монгол Улсын "Төрийн байгууллагын цахим хуудсанд тавигдах шаардлага MNS6285:2017" стандартыг хангах, стандартын дагуу цахим хуудсыг ажиллуулах;

4.5 Байгууллагын хэмжээнд албан ёсны цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журам боловсруулж, мөрдөж ажиллах;

4.6 Байгууллагын албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж, мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тухай бүр, хугацаанд нь хийж, мэдээллийг үнэн зөв, бүрэн, иргэнд ойлгомжтой байхаар байршуулж хэвших;

4.7 Байгууллагын албан ёсны цахим хуудасны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, эрчимжүүлэх;

4.8 Үнэлгээгээр байршуулаагүй байсан, 0 үнэлгээ авсан мэдээллүүдийг бүрэн, ил тод байршуула;

4.9 Чанарын үзүүлэлтийн биелэлтийг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;

4.10 Хэрэглэгчийг мэдээ, мэдээллээр хангахад чирэгдэл үүсгэхгүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг цаг тухайд нь хүргүүлэхэд хяналт тавьж ажиллах.

Тав. Нэгдсэн үнэлгээ

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Жин	Оноо
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	91.8	0.2	18.4
2	ТАХ-ийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	90.0	0.15	13.5
3	Мэдээллийн ил тод байдлыг илтгэх үзүүлэлт	70.7	0.15	10.6
4	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт	50.0	0.3	15.0
5	Хэрэглэгчийн үнэлгээ	90.0	0.2	18.0
6	Ерөнхий үзүүлэлт			75.5

Эрүүл мэндийн яам
2025 оны 04 дүгээр сар

Эрүүл мэндийн хөгжлийн төв

№	Шалгуур үзүүлэлт	2023	2024
1	Телемедицин ашиглаж авсан оношилгоо, эмчилгээний зөвлөгөөний хувь	2588	115
2	Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой нотлогдсон гомдлын тоо (дотоод болон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн)	0	0
3	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалттай холбоотой нотлогдсон гомдлын тоо	3	1
4	Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой нотлогдсон гомдлын тоо	0	0
5	Эрүүл мэндийн ажилтны мэдээний нэгдсэн сангийн баяжилт, тогтвортой үйл ажиллагаа	60153	68529
6	Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудад явцын хяналт хийж, зөвлөмж өгсөн байгууллагын тоо	33	44
7	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг алдаа, зөрчлийн мэдээллийн санд бүртгэгдсэн хувь	12	4
8	Тухайн мэргэжлийн чиглэлээр явуулсан мэргэжил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт болон хамрагсдын тоо	0	0
9	Эрдмийн зэрэг хамгаалсан хүний тоо	0	0
10	Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь	0	0
	Нэгдсэн дүн	50	